



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/566

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
чанарыг сайжруулах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.3, 8.1.6, 8.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, хариу арга хэмжээ авах журам, мэдээлэх хуудас”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, тайлагнах заавар”-ыг гуравдугаар, “Эрүүл мэндийн байгууллагад ижил мэргэжилтний үнэлгээ хийх нийтлэг заавар”-ыг дөрөвдүгээр, “Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн хөгжлийн төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэг”-ийг тавдугаар, “Эрүүл мэндийн байгууллагын Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны ажилтнуудын чиг үүрэг”-ийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Журам, заавар, аргачлалыг мөрдүүлж, удирдлагаар ханган, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нар, т, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг эмнэлгийн тусламжийн газар (Я.Буюнжаргал)-д, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д, Эрүүл мэндийн даатгалын газар (Г.Баясгалан)-д даалгасугай.
4. Тушаалыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
5. Энэ тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2011 оны 349, 2012 оны 274, 2012 оны 375 тоот тушаалын хоёр, гурав, дөрөв, зургаадугаар хавсралт, 2013 оны 437 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

082070

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮССЭН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудад (цаашид тохиолдол гэх) дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоох, мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хариу арга хэмжээ авахтай холбоотой асуудлыг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын зорилго нь тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах, давтан гарахаас сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагууд харилцан суралцах замаар тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад оршино.

1.3. Тохиолдолд дүн шинжилгээ хийн хариу арга хэмжээ авахдаа байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй шалтгааныг нэн тэргүүнд олж илрүүлэн үндсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоох бөгөөд тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр аливаа дүгнэлт гаргахгүй.

1.4. Энэ журмаар зохицуулагдаж байгаа үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцлүүдийг дараахь байдлаар шалтгаан болгоно.

1.4.1. Тохиолдол - Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй байдлыг;

1.4.2. Алдах дөхсөн тохиолдол – Үйлчлүүлэгчид хохирол учруулж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдлийг;

1.4.3. Таагүй тохиолдол - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдлыг;

1.4.4. Ноцтой тохиолдол - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад үйлчлүүлэгч ноцтойгоор хохирох, эсвэл амь насаа алдахад хүргэсэн үр дагаврыг;

1.4.5. Эмнэлгийн алдаа – Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжихгүй байх эсвэл буруу төлөвлөн хэрэгжүүлсэн, зөв төлөвлөсөн үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсэн үйлдлийг;

1.5. Энэхүү журмын 1.4.-д заасан тохиолдлуудын үндсэн шалтгааныг дараах байдлаар тодорхойлно.

1.5.1. Үйлчлүүлэгчийг танин тодруулга

1.5.2. Харилцааны дутагдал, доголдол

1.5.3. Эмийн аюулгүй байдал

1.5.4. Мэс заслын аюулгүй байдал

1.5.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний халдвар

1.5.6. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унасан

1.5.7. Бусад шалтгаан

1.6. Энэхүү журмын 1.4.-д заасан тохиолдлуудын нөлөөлөл хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлно.

- 1.6.1. Үйлчлүүлэгчийн хүчин зүйл
- 1.6.2. Хувь хүн/ ажилтны хүчин зүйл
- 1.6.3. Ажлын болон үйлчилгээний орчны хүчин зүйл
- 1.6.4. Багийн хүчин зүйл
- 1.6.5. Баримт бичиг/ технологийн хүчин зүйл
- 1.6.6. Бүтэц, зохион байгуулалтын хүчин зүйл

1.7. Байгууллага бүр өөрийн тусламж, үйлчилгээний өвөрмөц онцлогтой холбоотой энэхүү журмын 1.4-д заасан тохиолдлуудад тооцогдох жагсаалтыг гарган батлуулна.

1.8. Мэдээлэл харилцаа холбооны давуу талыг ашигласан тохиолдол бүртгэн мэдээлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах мэдээллийн сан үүсгэсэн байна.

Хоёр. Тохиолдлыг бүртгэх, мэдээлэх ерөнхий зарчим

2.1. Эрүүл мэндийн байгууллагын ажилтан бүр тохиолдлыг шуурхай мэдээлэх үүрэгтэй.

2.2. Тохиолдлын мэдээлэлд дүн шинжилгээ хийлгүйгээр эрүүл мэндийн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэхгүй.

2.3. Тохиолдол мэдээлэх, бүртгэх, үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх бүхий л үйл ажиллагаа баримтжуулагдсан байна.

2.4. Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмын дагуу эрүүл мэндийн байгууллагын эрх бүхий ажилтан мэдээлэл илгээнэ. Сангаас мэдээллийг тухайн эрүүл мэндийн байгууллагад олгогдсон эрхийн дагуу эрүүл мэндийн ажилтан бүр нэвтэрч мэдээлэл авч болно.

2.5. Мэдээлэгдсэн тохиолдлууд мэргэжлийн индексийн дагуу тохиолдлын нэгдсэн санд бүртгэгдэнэ.

2.6. Тохиолдлын нэгдсэн санд бүртгэгдсэн тохиолдлууд нь хэрэглэгчдэд орон нутаг, эрүүл мэндийн байгууллагын нэр, эрүүл мэндийн ажилтан, үйлчлүүлэгчийн нэр хаяггүйгээр гарсан тохиолдол, шийдвэрлэсэн арга зам хэлбэрээр харагдах бөгөөд зөвхөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, харилцан суралцах, туршлагаа хуваалцах зорилгоор хэрэглэгдэнэ.

2.7. Тохиолдлыг илрүүлэн мэдээлсэн ажилтныг зэмлэн буруутгах бус эерэг, бүтээлч арга замаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагаанд оролцсонд тооцно.

Гурав. Эрүүл мэндийн байгууллагад тохиолдлыг ангилах, бүртгэх, мэдээлэх

3.1. Тохиолдлыг анх харсан, оролцсон, илрүүлсэн ажилтан “Тохиолдлыг мэдээлэх хуудас”-ыг бөглөж, ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ. Тохиолдол мэдээлэх хуудсыг цахим болон цаасан хэлбэрээр тасаг/нэгж бүрт байршуулах бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллага, эмнэлэгт хэрэглэгддэг мэдээлэл харилцаа холбооны хэрэгслээр мэдээлэгдэж болно.

3.2. Тухайн эрүүл мэндийн байгууллагад гарсан бүх тохиолдолд ЭМТҮЧАБ-ын алба/баг дугаар олгоно. Тохиолдлын дугаар нь тухайн байгууллагад хөтлөгддөг баримт бичгийн тогтолцооны онцлогийг тусгасан дахин давтагдахгүй дугаар байна. Мэдээлэгдсэн тохиолдлыг ЭМТҮЧАБ-ын алба/баг ангилан цаалид авах арга хэмжээний чиглэлийг гаргана.

3.3. Энэ журмын 1.4.1-д заасан нөхцөл байдал үүссэн бол 1А гэж бүртгэн тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба /баг/-д мэдээлнэ.

3.4. Энэ журмын 1.4.2-т заасан “Алдах дөхсөн тохиолдол”-д түүнийг 1Б гэж бүртгэн, тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг хэлэлцэн авсан арга хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ.

3.5. Энэ журмын 1.4.3-т заасан “Таагүй тохиолдол”-д түүнийг 2 гэж бүртгэн, ЭМТҮЧАБ-ын алба/баг хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.

3.6. Энэ журмын 1.4.4-т заасан “Ноцтой тохиолдол”- д түүнийг 3 гэж бүртгэн ЭМТҮЧАБ-ын алба/баг байгууллагын удирдлагад мэдээлж, хэлэлцэн эрүүл мэндийн газарт, Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд, Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эрүүл мэндийн яаманд тус тус мэдээлнэ.

3.7. Энэ журмын 1.4.5-д заасан “Эмнэлгийн алдаа” гэж тогтоогдсон бол холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

3.8. 1А, 1Б ангилалд хамаарах тохиолдлыг тасаг/нэгжид сургалт зохион байгуулах, тохиолдол гаргах шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх зэрэг арга хэмжээ авч, ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ.

3.9. Тохиолдол нь 2, 3 ангилалд хамаарагдаж байвал ЭМТҮЧАБ-ын алба/баг нь дүн шинжилгээний багийг зохион байгуулна.

3.9.1. Дүн шинжилгээний багт эмнэлзүйн тухайн чиглэлээр мэргэшсэн болон ашиг сонирхолын зөрчилгүй, хараат бус шийдвэр гаргах чадвартай мэргэжилтнүүдийг сонгох ба тогтолцоо, үйл явц, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн зөвлөмж, дүгнэлт гаргана.

3.9.2. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь хариу арга хэмжээний төлөвлөгөөг дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсруулж хэрэгжилтийг ханган тайлагнана.

3.10. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн хяналт хийх дүн шинжилгээний багийг Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар томилон ажиллуулж болно.


3.11. Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сөрөг мэдээллийг ЭМТҮЧАБ-ын алба/баг нэр тохиолдол гэж бүртгэх бөгөөд дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авна.

3.12. Тохиолдлын нэгдсэн сангийн ажиллах журмын дагуу тухайн эрүүл мэндийн байгууллагаас эрх олгогдсон ажилтан мэдээлэл илгээнэ.

Хүснэгт 1. Тохиолдлын үр дагаврын ангилал, мэдээлэх түвшин

Ангилал	Тохиолдлын тодорхойлолт	Тохиолдлын зэрэглэл	Тохиолдлын үр дагаврын ангилал	Авах арга хэмжээ, мэдээлэл түвшин
Тохиолдол	Анхаарал татсан нөхцөл байдал үүсэх	1А	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид гэмтэл учруулаагүй, аюулгүй байдал, байгууллагын нэр хүндэд нөлөөлөөгүй	Тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн авсан арга хэмжээг ЭМТҮЧАБ-ын алба/багт мэдээлнэ.
Алдах дөхсөн тохиолдол	Хор хөнөөлд хүргэж болзошгүй байсан ч таслан зогсоосон үйлдэл.	1Б	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт, гэмтэлийн хэмжээ бага	ЭМТҮЧАБ-ын алба/багт хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.
Таагүй тохиолдол	Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үйлчлүүлэгчид сөрөг үр дагавар үзүүлсэн нөхцөл байдал үүсэх	2	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт үзүүлсэн, хор уршиг учруулаагүй боловч гомдоосон, байгууллагын нэр хүндэд нөлөөлсөн	ЭМТҮЧАБ-ын алба/багт хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.
Ноцтой тохиолдол	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад өвчтөнд бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах, эсвэл амь насаа алдахад хүргэсэн ямар нэг урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүсэх	3	Ажилтан, үйлчлүүлэгч, зочны биемахбодид түр зуурын өөрчлөлт үзүүлсэн, хор уршиг учруулаагүй боловч гомдоосон, байгууллагын нэр хүндэд нөлөөлсөн	ЭМТҮЧАБ-ын алба/багт хэлэлцэн байгууллагын удирдлагад мэдээлнэ.

Зураглал 1. Тохиолдлыг мэдээлэх, бүртгэх үйл явц



Тайлбар: Тохиолдол мэдээлэх урсгал
 Шаардлагатай тохиолдолд мэдээлэх, арга хэмжээ авах урсгал

Тасаг/нэгж/-ийн түвшин, ЧАБА-ны түвшин, Байгууллагын түвшин,
 ЭМХТ, АЭМГ, НЭМГ түвшин, ЭМЯ-ны түвшин

5.2. ЭМТҮЧАБА-аас тасаг/нэгжид цохогдоно. /1А, 1Б тохиолдолд хөтлөгч/

Б хэсэг. Хамаарах тасаг/нэгжид илгээнэ.	Тохиолдлын №.....	
Тасаг/нэгж:		
Шалтгаан: Хувь хүнтэй холбоотой <input type="checkbox"/>	Тогтолцоотой холбоотой	<input type="checkbox"/>
Тохиолдлын зэрэг: 1А 1Б		
Тохиолдлын үндсэн шалтгаан:/ журмын 1.5. харна/		
Нөлөөлөх хүчин зүйл:/ журмын 1.6. харна/		
Тасаг/нэгжээс авсан арга хэмжээ:		
Тасгийн эрхлэгч:	
/нэр/	/гарын үсэг/	
Танилцсан:		
ЭМТҮЧАБ-ын албаны эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер		
.....	
/нэр/	/гарын үсэг/	
.....онсарөдөр		

5.3. ЭМТҮЧАБ-ЫН АЛБА /БАГ/- Д ХӨТЛӨГДӨХ ТОХИОЛДЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

А Хэсэг: ЭМТҮЧАБ-ын алба /баг/ бөглөнө.	Тохиолдлын №.....
Тасаг/нэгж.....	
Тохиолдсон явдал:	
Тохиолдлын зэрэг: / журмын 1.4, 3.11 харна/ 2 3 Нийгмийн сүлжээгээр түгээгдсэн	
Шалтгаан:/ журмын 1.5. харна/ 1 2 3 4 5 6 7	
Нөлөөлөх хүчин зүйл: / журмын 1.6. харна / 1 2 3 4 5 6 7	
Хэрэгжүүлсэн арга хэмжээ:	
Чанар сайжруулах арга хэрэгсэл:	
Эргэх холбоо:/ дугуйлна уу/	
<ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын удирдлагад 2. Тохиолдол мэдээлсэн ажилтанд 3. Үйлчлүүлэгч, түүний ар гэрт 4. Холбогдох эрүүл мэндийн байгууллагад 5. Эрүүл мэндийн газарт 6. Эрүүл мэндийн хөгжлийн төв 	
ЭМТҮЧАБ-ын алба /баг/-ны дэд захирал, дарга	/гарын үсэг/
.....онсарөдөр	

5.4. ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ ХУУДАС БӨГЛӨХ ЗААВАР

Байгууллагын нэр: Өгсөн зайд тухайн эмнэлэг, байгууллагын нэрийг бичнэ.

Байршил: Тохиолдол болсон тасаг/нэгжийг бичнэ. Нэгээс илүү тасгийн нэр бичиж болно.

Тохиолдол болсон огноо: Тохиолдол болсон огноог өдөр/сар/он/ нэсэн форматаар бичнэ. Эргэлзэж байгаа үед өдрийг ойролцоогоор бичиж болно.

Тохиолдол болсон хугацаа: Тохиолдол болсон хугацааг / цаг / минут / форматаар бичнэ. Эргэлзэж байгаа үед хугацааг ойролцоогоор бичиж болно.

Тохиолдол: Тухайн тохиолдол хэрхэн гарсан, тохиолдохоос өмнө буюу тухайн үед болж байсан үйл явцын талаар бичнэ. Тохиолдол гарахад хүргэж болзошгүй нэмэлт мэдээллийг бичиж болно.

Мэдээлсэн хүний нэр: Нэрийг гаргацтай тод бичиж, гарын үсгээ зурна.

Албан тушаал: Эрхэлдэг албан тушаалаа бичнэ.

Тохиолдлын дугаар: ЭМТҮЧАБ-ын алба/багаас тохиолдлын дугаар авна.

Тасаг/нэгж: Тохиолдол гарсан, тохиолдолтой холбоотой тасаг/нэгжийн нэрийг бичнэ.

Тохиолдлын шалтгаан: Үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээ хийн шалтгааныг тодорхойлсон тухай бичнэ. Тухайн тохиолдол хувь хэнтэй холбоотой, тогтолцоотой холбоотой аль нь болохыг сонгож бичнэ.

Тохиолдлын зэрэг: 1А, 1Б, 2, 3 гэсэн зэрэглэлд аль хамаарахыг дугуйлж тэмдэглэнэ.

Тасаг/нэгжээс авсан арга хэмжээ: Тохиолдлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, үр дагаварыг арилгах, дахин давтагдахаас сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ. Мөн бусад тасаг/нэгжүүдэд ийм төрлийн тохиолдол давтагдахаас сэргийлсэн үйл ажиллагааг чанар аюулгүй байдлын алба /баг-тай хамтран зохион байгуулсан талаар бичиж болно.

Гарын үсэг: тод гаргацтай, тайллын хамт бичигдсэн байна.

Шалтгаан: Үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээний дүнд тохиолдол гаргахад хүргэсэн шалтгаан гэж тодорхойлсныг бичнэ.

Нөлөөлөх хүчин зүйл: үндсэн шалтгааныг илрүүлэх дүн шинжилгээний дүнд тохиолдол гаргахад нөлөөлсөн хүчин зүйл гэж тодорхойлсныг бичнэ.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ: ЭМТҮЧАБ-ын алба/баг байгууллагын удирдлагатай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ.

Чанар сайжруулах арга хэрэгсэл: Ийм тохиолдол давтагдахаас сэргийлэн мэдээллийг түгээх, бусад тасаг / нэгж/-д тохиолдол гарах шалтгаан нөлөөлөх хүчин зүйл байгаа бол арилгуулах арга хэрэгсэл хэрэглэснийг бичнэ.

Эргэх холбоо: Эргэх холбоо тогтоон хариу мэдээлэл хүргэсэн байгууллага, хувь хүнийг сонгон тэмдэглэл хийнэ.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 12 -ны
өдрийн А/566 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРСДЭЛИЙГ БҮРТГЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах заавар, журамтай байна.

1.2. Эрсдэлийн удирдлага гэдэг нь тухайн байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, шилжүүлэх, нэгэнт аюул осол, эрсдэл нүүрлэсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдлээс ангид байх цогц үйл ажиллагаа юм.

1.3. Эрсдэлийн удирдлага нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн тасралтгүй үргэлжлэх үйл явц болно.

1.4. Эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдлын нэг тэс, алба, баг нь эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, ажилтнуудыг сургах үүрэгтэй.

Хоёр. Эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах

2.1. Эрүүл мэндийн байгууллагын чанар, аюулгүй байдлын алба /баг нь эрсдэлийг дараахь дарааллаар тогтооно.

2.1.1. Эрсдэлийг илрүүлж, нөхцөл байдлыг тодорхойлно.

2.1.1.1 Өдөр тутмын үйл ажиллагааны явцад дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүсч болох эрсдэлийн хүчин зүйлс, тэдгээрийн шалтгаан, үр дагаврыг тохиолдол мэдээлэх хуудас, үйл ажиллагааны явцын хяналт, аюулгүй байдлын тойрон үзлэг, албан ба албан бус мэдээлэл, санал, гомдолд тулгуурлан тогтооно.

2.1.1.2 Эрсдэлийг илрүүлэхдээ нотолгоо бүхий дараахь баримт, мэдээ, мэдээллийг ашиглана.

- ✓ Өмнөх туршлага,
- ✓ Мэргэжлийн хяналт болон аудитын дүгнэлт,
- ✓ Давтамж өндөртэй тохиолдолд хийсэн дүгнэлт,
- ✓ Тохиолдлын бүртгэл,
- ✓ Эмгэг судлалын тэмдэглэл,
- ✓ Байгууллагад хийгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээний дүн
- ✓ Мэргэжлийн байгууллагын анхааруулга
- ✓ Ханган нийлүүлэгч байгууллагын анхааруулга
- ✓ Хүний нөөцийн хангамж, хүртээмж, мэргэшсэн байдал
- ✓ Ёс зүйн асуудал

2.1.2. Эрсдэлийг тодорхойлно. Цуглуулсан баримт, мэдээ, мэдээлэл дээр үндэслэн эрсдэлт хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж, эрсдэлийн төрөл, хугацаа, давтамжийг харгалзан магадлал, түүнээс үүдэн гарах үр дагаварыг тогтооно.

2.1.2.1. Эрсдэлийг тохиолдох магадлалаар нь дараах байдлаар ангилна.

- Маш ховор
- Ховор
- Магадлалтай
- Тодорхой
- Өндөр магадлалтай

Хүснэгт 1. Эрсдэлийн ангилал, зэрэглэл

Магадлал		Бүртгэгдсэн давтамжийн тоо	
Зэрэглэл	Ангилал	Эмнэлзүйн эрсдэл	Гадаад, орчлон орчны эрсдэл
1	Маш ховор	3 буюу түүнээс дээш жилд 1 удаа	10-аас дээш жилд 1 удаа
2	Ховор	Жилд 1 удаа	5-10 жилд 1 удаа
3	Магадлалтай	Сард 1 удаа	3-5 жилд 1 удаа
4	Тодорхой	7 хоногт 1 удаа	1-3 жилд 1 удаа
5	Өндөр магадлалтай	Өдөрт 1 удаа	Жилд 1-ээс олон удаа

2.1.2.2. Эрсдэл тохиолдоход үүсч гарах үр дагавараар нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хор хөнөөлгүй
- Бага зэрэг
- Дунд зэрэг
- Өндөр
- Ноцтой

Хүснэгт 2. Эрсдэлийн үр дагавар

Зэрэглэл	Үр дагавар	Тайлбар
1	Хор нөлөөгүй	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, байгаль орчинд сөргөөр нөлөөлөөгүй, санхүүгийн алдагдалгүй, холбогдох хууль, журам тогтвортой
2	Бага зэрэг	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл бага зэрэг, санхүүгийн алдагдал бага, холбогдох хууль, журамд бага хэмжээний өөрчлөлт орох, хүлээгдэж чирэгдэл үүсэх
3	Дунд зэрэг	Эмчилгээ шаардлагатай, байгаль орчинд дунд зэргийн үр дагавартай, санхүүгийн алдагдалтай, холбогдох хууль, журамд нэлээн өөрчлөлт орох, түр хугацааны хөдөлмөрийн чадвар алдалт, эмчилгээ үйлчилгээ түр хугацаагаар тасалдах
4	Өндөр	Хувь хүн, байгууллагын нэр хүнд, барилга байгууламж, санхүүгийн хор нөлөө ихтэй, холбогдох хууль, журамд нэлээд өөрчлөлт орж шинэчлэгдсэн, удаан хугацааны хөдөлмөрийн чадвар алдалт үүсэх, эмчилгээ, үйлчилгээ удаан хугацаагаар тасалдах
5	Ноцтой	Нас баралт, хүнд гэмтэл, байгаль орчинд аюултай үр дагавар, санхүүгийн асар их алдагдал, холбогдох хууль, журам хүчингүй болсон, байнга өөрчлөгдөж байдаг, үйл ажиллагаа зогсох

2.1.3. Эрсдэлийг үнэлнэ.

2.1.3.1. Эрсдэлийн түвшинг тоон утгаар тогтооно.

2.1.3.2. Эрсдэлийг түвшинг тоон утгаар илэрхийлэгч үндсэн гол хэмжүүр нь магадлал болон үр дагавар юм. Магадлал нь үзэгдэх давтамжаар, харин үр дагаварыг үзүүлэх нөлөөлөл, хохиролоор хэмжинэ.

$$\text{Магадлал} \times \text{Үр дагавар} = \text{Эрсдэлийн зэрэг}$$

2.1.3.3. Эрсдэлийн үнэлгээний матрицыг ашиглана.

Хүснэгт 3. Эрсдэлийн үнэлгээний матриц

Магадлал	Үр дагавар				Ноцтой
	Хор хөнөөлгүй	Бага	Дунд	Өндөр	
Ховор	1	2	3	4	5
Магадлал багатай	2	4	6	8	10
Магадлалтай	3	6	9	12	15
Магадлал ихтэй	4	8	12	16	20
Тодорхой	5	10	15	20	25

Эрсдлийн шинжилгээний матрицад эрсдлийн зэргийг харгалзах тоонд тохируулан ногоон, хув, улаан өнгөөр тодотгосон байна.

Бага зэрэг - Ногоон өнгө нь тохиромжтой түвшин буюу эрсдэлд тохирсон зохицуулгын механизм байгааг илтгэнэ.

Дунд зэрэг - Шар өнгө нь тохиромжгүй түвшин буюу эрсдлийг удирдахад тохиромжгүй байгааг илтгэнэ.

Их зэрэг - Улбар шар өнгө нь одоо ашиглаж байгаа зохицуулгын механизмд дутагдал, сул талтай, анхаарч өөрчлөх шаардлагатайг илтгэнэ.

Ноцтой - Улаан өнгө нь одоо ашиглаж байгаа зохицуулгын механизмд ноцтой дутагдал, сул талтай, хяналтгүй эрсдэл байгааг илтгэнэ.

2.1.4. Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ авна. Дараахь 4 үндсэн аргын аль нэгийг сонгон ашиглана.

2.1.4.1. Эрсдэлийг арилгах: Тухайн эрүүл мэндийн байгууллагад эрсдэл учруулах үйл ажиллагааг зогсоох, эрсдлээс зайлсхийх тодорхой арга зам нэвтрүүлэх замаар эрсдлийг арилгана.

2.1.4.2. Эрсдэлийг бууруулах, багасгах: Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүртэл бууруулна.

2.1.4.3. Эрсдэлийг шилжүүлэх: Тухайн эрүүл мэндийн байгууллага эрсдэлээ даатгуулах юм уу өөр арга зам ашиглах замаар /байгууллага хэсэг бүлэг хүн/-д шилжүүлдэг.

2.1.4.4. Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх: Эрсдэлээс үүдэн гарах хохирол, алдагдлыг тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө хариуцна гэж үзэн тодорхой эрсдлийг хүлээн зөвшөөрдөг.

2.1.4.5. Эрсдлийг бууруулах арга хэмжээг авахдаа эрсдэлийн зэргийн хүснэгт ашиглана.

Хүснэгт 4. Эрсдэлд хариу арга хэмжээ авах, эргэн хяналт

Зэрэглэл	Ангилал	Харгалзах өнгө	Шийдвэрлэх арга зам	Эргэн хяналт
1-3	Бага	Ногоон	✓ Нэгжийн түвшинд зэрэглэл бууруулах үйл ажиллагаа зохион байгуулна.	Жилд 1 удаа эргэн хянана.
4-6	Дунд	Шар	✓ Чанар, аюулгүй байдлын албанд мэдэгдэнэ. ✓ Нэгжийн түвшинд шийдвэрлэх Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллана.	Улирал тутам, хагас жилд эргэж хянана.
7-12	Өндөр	Улбар шар	✓ Байгууллагын удирдлагад мэдэгдэнэ. ✓ Үйл ажиллагааны төлөвлөгөө яаралтай гаргаж, холбогдох арга хэмжээ авах шаардлагатай	Хагас жил, жилд эргэн хянана. Гүйцэтгэлийн хяналт хийнэ.
13-25	Ноцтой	Улаан	✓ Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ. ✓ Ажлын хэсэг томилон арга хэмжээ авна. ✓ Нэн даруй арга хэмжээ шаардлагатай	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд хяналт тогтмол хийнэ.

2.1.5. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийнэ. Хяналт шинжилгээг дотоодын болон хөндлөнгийн байгууллагаар хийлгэж болно.

Гурав. Эрсдэлийг мэдээлэх

3.1. Эрүүл мэндийн байгууллагууд эрсдэлийг бүртгэн үнэлгээ хийн, эрэмбэлж, энэхүү журмын 3.2-т заасны дагуу мэдээлнэ.

3.2. Эрсдэлийг мэдээлэхдээ дараахь байдлаар ангилна.

3.2.1. Эрсдэлийн үнэлгээний оноо 1-6 бол бага, дунд зэргийн эрсдэл гэж үзэн байгууллагын түвшинд зохицуулан шийдвэрлэнэ.

3.2.2. Эрсдэлийн үнэлгээний оноо 7-12 бол өндөр эрсдэл гэж үзэн сум, тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв,

амаржих газар, сувилахуйн төв, нэгдсэн эмнэлэг, сувилал, клиник, тусгай эмнэлэг, тусгай тусламжийн төв, сэргээн засах төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь улирал тутам харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрсдэлийн санд мэдээлнэ.

3.2.3. Эрсдэлийн үнэлгээний оноо 13-25 бол ноцтой эрсдэл гэж үзэн Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрсдэлийн санд шууд мэдээлнэ.

3.3. Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын чанар, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн хэлтэс өөрийн харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудаас илгээсэн эрсдэлийг эрэмбэлж хамгийн ноцтой, эндөр ангилалд хамаарахаас нь эхлэн холбогдох байгууллагуудтай хамтран эрсдэлийг арилгах, бууруулах, шилжүүлэх арга хэмжээ авна.

Дөрөв. Эрсдэлээс сэргийлэх талаар удирдлагын баг, ажилтнуудын хүлээх үүрэг

4.1. Эрүүл мэндийн байгууллага нь Удирдах зөвлөлтэй бол удирдах зөвлөл нь дараахь үүргийг хүлээнэ.

4.1.1. Эрүүл мэндийн байгууллагын гадна болон дотоод орчин, эмнэл зүйн эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлон батлана.

4.1.2. Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлагын багийн гишүүдийн чиг үүргийг тодорхойлж үүрэгжүүлнэ.

4.1.3. Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, эрсдэлийн удирдлагын багийн чиг үүрэг, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтэнд гүйцэтгэлийн үнэлгээ хийнэ.

4.1.4. Эрүүл мэндийн байгууллагын эрсдэлийн удирдлагын талаар хэрэгжүүлсэн тайланг хэлэлцэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлно.

4.2. Эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга

4.2.1. Байгууллагын ерөнхий захирал, дарга нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрсдэлийн удирдлагатай холбоотой бүх шийдвэр, тушаалыг биелүүлэх, эрсдэлийн удирдлагын журмыг дагаж мөрдөх, эрсдэлийн менежмент, аюулгүй ажиллагааны тогтолцоог үр дүнтэй ажиллуулах үүрэг хүлээнэ.

4.2.2. Ерөнхий захирал, дарга нь төлөвлөгөөнд заасны дагуу жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдэлийн удирдлагын талаар тусгай үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.3. Төлөвлөгөөнд тухайн байгууллагын хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ, орчин нөхцөлөөс шалтгаалан эрсдэлийн удирдлагын зорилго, зорилтуудыг тодотгон, тулгарч буй эрсдэлтэй холбоотой шийдвэрлэх арга зам, чанар, аюулгүй байдлын албаны санхүү хөрөнгийн эх үүсвэр, хамтрагч талууд, гүйцэтгэлд хяналт тавих зэргийг багтаасан байна.

4.2.4. Захирал, дарга нь эрсдэлийг бусад талуудтай хамт үүрэх, эрсдэлийг шилжүүлэх үүднээс тухайн байгууллагын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг даатгуулах шийдвэр гаргана.

4.2.5. Эрсдэлийн менежментийн цар хүрээ, эрсдэлийн менежментийн үйл явцад гүйцэтгэлийн түвшин шаардлагатай буюу хүлээгдэж байгаа хэмжээнд байгаа эсэхийг тогтоох зорилгоор нөхцөл байдлыг тодорхойлох буюу ажиглах, зөвлөх, тогтмол шалгалт хийх мониторингийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

4.3. Дотоод аудитор эсвэл Санхүүгийн албаны дарга

4.3.1. Санхүүгийн албаны дарга захирлын өмнө санхүүгийн эрсдэлийн удирдлага, түүнд тавих хяналтын үйл ажиллагааг хариуцан ажиллана.

4.3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тухайн эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны нээлттэй байдал, нягтлан бодох бүртгэлийн механизмаар хянадаг тогтолцоотой байх, хяналт хийх үүрэг хүлээнэ.

4.4. Сувилахуйн албаны дарга

4.4.1. Сувилахуйн албаны дарга нь эрсдэлийн удирдлагын багийн гишүүн бөгөөд ерөнхий захирлын өмнө сувилахуйн тусламж, үйлчилгээний эрсдэлийн удирдлагын үйл явцыг хариуцан ажиллана.

4.4.2. Байгууллагын эрсдэлийг удирдлагын зохицуулалтыг хангахад ахлах сувилагч нарт тодорхой чиглэлийг өгнө.

4.4.3. Сувилахуйн албаны дарга нь хариуцсан үйл ажиллагааныхаа хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд сувилахуйн тусламж, үйлчилгээний тохиолдол, ноцтой үйл явдлаас үүдэн гарах эрсдэлийг зохих ёсоор удирдаж, тайлагнах, үйл явцыг төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

4.4.4. Сувилахуйн албаны дарга нь алдаанаас суралцах тогтолцоог ханган ажиллаж өөрсдийн үйл ажиллагааны чиглэл дэх эрсдэлийг бүртгэх, мэдээлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бууруулах, эрсдэлээс сиргүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.

4.5. Тасаг/нэгжийн дарга, эрхлэгч

4.5.1. Тасаг/нэгжийн дарга, эрхлэгч үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бүртгэх, мэдээлэх, журамд заасны дагуу хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг өөрийн удирдаж буй нэгж дээр гардан хэрэгжүүлж, дахин давтагдахаас сэргийлэх, бууруулах арга хэмжээ авна.

4.5.2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол бусад тасаг/нэгжид тохиолдох эрсдэлээс сэргийлэх үүднээс мэдээлэл, туршлагаа хуваалцах үйл ажиллагааг чанар, аюулгүй байдлын албатай хамтран хэрэгжүүлнэ.

4.5.3. Өөрсдийн хариуцсан нэгжийн хүрээнд өртөж болзошгүй эрсдэлийг бүртгэн мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийн арилгах, бууруулах арга хэмжээг эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежертэй хамтран төлөвлөж хэрэгжүүлнэ.

4.5.4. Хариуцсан нэгжийн хэрэгжүүлж чадах эрх мэдлээс хэтэрсэн удирдах боломжгүй эрсдэлийн талаар эрсдэлийн баг, удирдлагад шуурхай мэдээлнэ.

4.6. Ажилтнууд

4.6.1. Эрүүл мэндийн байгууллагын бүх ажилтанууд эрсдэлийн удирдлагыг байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээ гэж ухамсарласан байна.

4.6.2. Хувь хүний (өвчтөн, ажилтан, гэрээт ажилтан гэх мэт) эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйл ажиллагааг өөрсдийн хариуцсан удирдлагадаа эрсдэл, тохиолдол мэдээлэх хуудсыг бөглөн мэдээлэх үүрэг хүлээнэ мэдээлнэ.

4.6.3. Хэрэв тохиолдол мэдээлсний дагуу ямар нэгэн хариу үйлдэл хийгдэхгүй байвал захиргааны удирдлагад шууд мэдээлнэ.

4.6.4. Өөрсдийн гүйцэтгэж буй ажилд шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл, тодорхой тэмдэглэгээ ашиглах гэх мэт аюулгүй ажиллагааны зохицуулгуудыг дагаж мөрдөнө.

4.7. Эрсдэлийн менежер

4.7.1. Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер нь байгууллагын эрсдэлийн багийн гишүүдтэй хамтран үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдалтай холбоотой гадаад, дотоод орчны эрсдэл, эмнэлгийн эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулна.

4.7.2. Байгууллагын өдөр тутмын үйл явц, дотоод болон гадаад орчны талаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөнд шинэчлэл хийх санал, төслийг боловсруулан, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.

4.7.3. Байгууллагын удирдлагын багт эрсдэлийн багийн үйл ажиллагааны талаар удирдлагад тайлагнана.

4.7.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой аюул, эрсдэлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээг баримтжуулан дүн шинжилгээ хийж түгээн дэлгэрүүлнэ.

4.7.5. Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлийн багийн үйл ажиллагааг холбогдох нэгжүүдтэй уялдуулах ажлыг зохион байгуулна.

4.7.6. Барилга байгууламжийн засвар үйлчилгээний өмнө, засварын явцад, засварын дараа гарч болох эрсдэл гэх мэт гадаад болон дотоод орчны эрсдэлээс сэргийлэх

арга хэмжээг эрсдэлийн багтай хамтран урьдчилан төлөвлөх шийдвэрлэж хэвшүүлнэ.

4.7.7. Эрсдэлийг бүртгэх, үнэлэх, эрэмблэх хариу арга хэмжээ авах талаар байгууллагын ажилтануудад сургалт зохион байгуулна.

4.7.8. Шаардлагатай баримт бичгийг хөтөлж, эрсдэлийн удирдлагын багийн хурлыг улирал тутам зохион байгуулна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ҮНЭЛЭХ, ТАЙЛАХ НАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллага нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /цаашид Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө гэх/ -г боловсруулж хэрэгжүүлнэ.

1.2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө нь эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, хөгжүүлэхэд чиглэнэ.

1.3. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс мэрэгжил арга зүйн зөвлөгөө авч боловсруулна.

1.4. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, удирдах зөвлөл баталж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, ЭМХТ хянан баталгаажуулна.

1.5. Магадлан итгэмжлэгдээгүй эрүүл мэндийн байгууллагуудын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хянан, тухайн эрүүл мэндийн байгууллагын дарга батална.

1.6. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг 3 хувь үйлдэж, батлагдсан хувийг харьяа Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус хүргүүлнэ.

Хоёр. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим, агуулга

2.1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулахдаа дараах зарчмыг баримтална:

2.1.1 Тухайн эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулсан;

2.1.2 Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн;

2.1.3 Нөөц бололцоонд тулгуурласан, хэрэгжихүйц;

2.1.4 Шалгуур үзүүлэлт нь хэмжихүйц, бодитой;

2.1.5 Ил, тод нээлттэй;

2.1.6 Батлагдсан загварын дагуу боловсруулсан байна.

2.2. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- 2.2.1. Зорилго
- 2.2.2. Зорилтууд
- 2.2.3. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 2.2.4. Хэрэгжүүлэх хугацаа
- 2.2.5. Шаардагдах нөөц
- 2.2.6. Үйл ажиллагааг хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан
- 2.2.7. Хүрэх үр дүн
- 2.2.8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Гурав. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнд тавигдах шаардлага

3.1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудыг тусгана.

- ЭМТҮ-ний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх,
- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх
- Үйлчлүүлэгчтэй төвтэй үйлчилгээний чанарыг сайжруулах
- Чанарын баталгаажилтыг хангах
- Эмнэлзүйн эрсдэлийг бууруулах
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах

3.2. Төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувийг он оноор, суурь түвшингээс ахисан хувиар тодорхой гаргаж, хэрэгжүүлнэ.

3.3. Үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх хугацаа, түүнд шаардагдах санхүүжилт хариуцах албан тушаалтныг тодорхой заана.

3.4. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тусгасан байна.

3.5. Баримт бичиг, статистик үзүүлэлтүүдэд тулгуурлан үндэслэл сайтай, өмнөх үетэй харьцуулан чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.

3.6. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэх шийдвэр гарснаас 45-60 хоногийн дотор шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийн дагуу хийх ажлыг нэмж тусган магадлан итгэмжлэлийн хугацаагаар хэрэгжүүлэн батлах ба төлөвлөгөөг аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтэн, ЭМХТ-ийн чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж хянан, ЭМХТ-ийн ерөнхий захирал баталгаажуулна.

3.7. Магадлан итгэмжлэгдээгүй эрүүл мэндийн байгууллага нь чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг 3 жилийн хугацаагаар хэрэгжүүлэх ба аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнээс арга зүйн зөвлөгөө авч, тухайн байгууллагын дарга батална.

Дөрөв. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх

4.1. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоодын ба хөндлөнгийн хяналт- шинжилгээ, үнэлгээ хийнэ.

4.2. Шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшингээр тоон ба чанарын үзүүлэлтийг ашиглан тодорхойлно.

4.3. Үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтлана.

- Үнэлгээний үйл ажиллагаа нээлттэй, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт нь ил тод байх;
- Үнэлгээ нь шалгуур үзүүлэлт, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- Үнэлгээний тайлан дүгнэлт нь тухайн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг тодорхойлсон, нотлогдохуйц байх;
- Үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;
- Үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч талын оролцоог хангасан байх;
- Үнэлгээний тайланд тусгагдсан мэдээллийн үнэн, бодит байдлыг байгууллагын удирдах албан тушаалтан хариуцдаг байх.

4.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь өөрийн хэргээр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төв, амаржих газар, сувилахуйн төв, нэгдсэн эмнэлэг, сувилал, клиник, түргэн тусламжийн төв, сэргээн засах төв, хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын төлөвлөгөөний хэрэгжилт, тайланд жил бүр дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.

4.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайланд жил бүр дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн байгууллага нь тасаг/нэгжийн төлөөлөл оролцсон багийг томилж, дотоодын үнэлгээг жил бүр хийнэ.

4.7. Хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээг ЭМЯ, Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулан хамтран хийж болно.

4.8. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ нь холбогдох журмаар зохицуулагдана.

4.9. Үнэлгээг дараах байдлаар хийнэ.

№	Үр дүн	Үнэлгээний хувь
1	Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн, үр дүн нь гарсан бол	100 хувь
2	Тухайн жилд тавьсан зорилтод бүрэн хүрээгүй боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ	90 хувь

	бүрэн авагдсан, үр дүн гарч эхэлж байгаа бол	
3	Тухайн жилд тавьсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх арга хэмжээ авагдсан, хөрөнгө санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн	80 хувь
4	Үйл ажиллагааны бэлтгэл ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд хийгдэж байгаа бол ажлын түвшинг харгалзан	70 -60 хувь
5	Тухайн үйл ажиллагааг хийх бэлтгэл ажил хийгдэж дуусаад, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол ажлын түвшинг харгалзан	50-40 хувь
6	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар бэлтгэл ажил хийгдэж эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан	30 -20 хувь
7	Бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол	10 хувь
8	Арга хэмжээ аваагүй бол	0

4.10. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай сайн /100-90%, хангалттай /89-70%/, хангалтгүй /69%-аас доош/ гэж дүгнэнэ.

Тав. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах

5.1. Эрүүл мэндийн байгууллага нь “Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-ний тайланг хагас бүтэн жилээр дүгнэж, жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор өөрийн харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

5.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь байгууллага тус бүрийн тайланд үнэлгээ, дүн шинжилгээ хийж, нэгдсэн тайлангийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд ирүүлнэ.

5.3. Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлгүүд нь жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд тайлангаа ирүүлнэ.

5.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, 5.3-т заасан эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн тайланд үнэлгээ, дүн шинжилгээ хийж, нэгдсэн дүгнэлт, санал, зөвлөмжийг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт хүргүүлнэ.

5.5. Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар нь нэгдсэн тайлантай танилцаж, санал өгсний дараа Эрүүл мэндийн хөгжлийн төв нь өөрийн цахим хуудаснаа байршуулж, нийтэд мэдээлэх ба холбогдох байгууллагуудад үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлнэ.

5.6. Тайланг цаасан болон цахим хэлбэрээр ирүүлнэ. Цаасаар ирүүлэх тайланг А4 хэмжээтэй цаасан дээр Arial үсгийн фондоор үсгийн өндөр 12-оор бичнэ. Тайланд холбогдох материалыг хавсарган ирүүлж болно.

5.7. Үнэлгээний дүнг эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн болон эрүүл мэндийн байгууллагын жилийн эцсийн үнэлгээнд ашиглана.

Зургаа. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”- ний загвар

6.1. /Магадлан итгэмжлэгдээгүй эрүүл мэндийн байгууллага/

БАТ. АВ.....

байгууллагын З.ХИРАЛ/ДАРГА /

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
(хэрэгжүүлэх хугацаа/жил)

6.2 Магадлан итгэмжлэгдсэн байгууллага бол:

Байгууллагын нэр:.....

“ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Батламжийн дугаар.....

Магадлан итгэмжлэгдсэн:он.....сар.....өдөр

Магадлан итгэмжлэгдсэн хугацаа: жил

Хөтөлбөр хянасан мэргэжилтэн:

№	Үйл ажиллагаа	он	он	он	он	он	Хүрэх үр дүн	Шаардагдах нөөц	Хариуцах нэгж, албан тушаалтан
	Зорилт 1: Чанар-аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах								
	Зорилт 2: Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлж, хэрэгжүүлэх түгээн зөвлөлийг элгэрүүлэх								
	Зорилт 3: Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх								
	Зорилт 4: Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх								
	Зорилт 5: Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх								
	Зорилт 6: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог олон улсын жишигт ойртуулах								
	Зорилт 7: Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах								

Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний баталгаажуулалт:

ЭМХТ-ийн ерөнхий захирал

Байгууллагын захирал/ дарга

**Долоо. Эрүүл мэндийн байгууллагын Чанар, аюулгүй байдлыг сайжруулах
төлөвлөгөөний хэрэгжилтийг Эрүүл мэндийн газарт тайлагнах хүснэгт**

Эрүүл мэндийн байгууллагын нэр.....

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хүрсэн үр дүн	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1:				
Зорилт 2:				
Зорилт 3:				
Зорилт 4:				
Зорилт 5:				
Зорилт 6:				
Зорилт 7:				
	Нийт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны нийт тоо хэмжээ	Бүрэн хэрэгжсэн тоо/хувь Хагас хэрэгжсэн тоо/хувь Хэрэгжүүлээгүй тоо/хувь		Хэрэгжилтийн нийт хувь
	Үнэлгээний дүн	<input type="checkbox"/> бүрэн хангалттай <input type="checkbox"/> хангалттай <input type="checkbox"/> хангалтгүй		

Байгууллагын дарга:

Тамга

.... он сар.... өдөр

Найм. Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хүснэгт

Эрүүл мэндийн газар:.....

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь			Хэрэгжилтийн нийт хувь	Үнэлгээний дүн
		Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3		
1.						
2.						
3.						
4.						
5.						
6.						
7.						
	Дүн					

Тайлан, дүгнэлт.....

Санал, зөвлөмж

.....

Байгууллагын дарга:

Тамга

.... он сар.... өдөр

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12-р сарын 12-ны
өдрийн А.156. дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ИЖИЛ МЭРГЭЖИЛТНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагааны гүйцэтгэлд ижил мэргэжилтний үнэлгээг (цаашид ИМҮ гэх) ашиглана.

1.2. Ижил мэргэжилтний үнэлгээ гэдэг нь эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, тухайн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хамт олны ажилтай уялдуулан бусаддаа үйл ажиллагаагаа танилцуулах, тасралтгүй боловсрол олгох, ажилтан, хамт олны хариуцлагыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, чанар сайжруулах гол аргын нэг мөн.

1.3. ИМҮ-г эрүүл мэндийн бүх байгууллагууд үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллана.

1.4. ИМҮ-нд байгууллагын бүх ажилтнуудыг хамруулна.

1.5. ИМҮ-г хийхдээ зөвлөлдөх, багаар ажиллах, асуудлыг шийдвэрлэх, харилцан хүндэтгэлтэй хандах, гүйцэтгэлийг бодитойгоор үнэлэх, үнэн зөв мэдээлэл өгөх зарчмыг баримтална.

1.6. Үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, нууцыг чанд сахина.

1.7. ИМҮ-г эрүүл мэндийн бүх байгууллагууд тогтмол хийнэ.

1.8. Эрүүл мэндийн байгууллагууд өөрийн тусламж, үйлчилгээний онцлогтой уялдуулан "Ижил мэргэжилтний үнэлгээний журам"-ыг боловсруулан хэрэгжүүлнэ.

Хоёр. Ижил мэргэжилтний үнэлгээ хийх

ИМҮ-г дараах чиглэлүүдээр хийж гүйцэтгэнэ.

2.1. Эрүүл мэндийн ажилтны үзүүлж буй мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанарыг тодорхойлох зорилгоор;

2.2. Үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гишүүд гомдол гаргасан болон дотоодын үнэлгээгээр тохиолдол илэрсэн үед;

2.3. Чанарын үнэлгээний хөндлөнгийн байгууллага буюу мэргэжлийн зохицуулах байгууллагын албан ёсны шалгалтаар үйл ажиллагааны доголдол илэрч шаардлага тавьсан тохиолдолд;

2.4. Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх шинэ удирдамж, стандарт нэвтрүүлсэн тохиолдолд удирдамж, стандартын хэрэгжилтийг зохион байгуулах, дэмжих зорилгоор хяналт үнэлгээний хэрэгсэл болгон ашиглах үед;

2.5. Чанар аюулгүй байдлын албанаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу.

Гурав. Ижил мэргэжилтний үнэлгээний чиглэлүүд

ИМҮ-г дараахь чиглэлээр тухайн байгууллагын ЭМТҮЧАБ-ын алба/багаас гаргасан хуваарийн дагуу төлөвлөж, байгууллагын бусад хороо, зөвлөл, алба/багтай хамтран хийж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

3.1. Эрүүл мэндийн сайдын баталсан эмнэл зүйн удирдамж, заавар, хяналтын хуудас, анхан шатны баримт бичгийн хөтлөлтийн үнэлгээ;

3.2. Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлийн болон бусад стандартууд;

3.3. Тухайн эрүүл мэндийн байгууллагын даргын баталсан хяналтын хуудсууд, үнэлгээний хуудсууд, үйлчилгээний заавар, журам;

3.4. Ажлын байрны тодорхойлтод заагдсан ажил үүрэг;

Дөрөв. Ижил мэргэжилтний үнэлгээ хийх аргачлал

4.1. Тасаг/нэгжийн эрхлэгч бусад алба /баг/-тай хамтран ИМҮ хийх чиглэл, давтамж, хуваарийг гарган ЭМТҮЧАБ-ын алба/багаар батлуулна.

4.2. ИМҮ нь мэргэжил нэгтний түвшинд хийгдэх тул эрүүл мэндийн мэргэжилтэн бүхэн үнэлгээ хийгч болон үнэлүүлэгчийн хувьд хамрагдана.

4.3. Тасаг/нэгжийн удирдлага ИМҮ хийх ажилтанууд, чанар аюулгүй байдлын алба нь хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг үнэлэх, гүйцэтгэж буй үйл ажиллагааг тухайн агшинд нь үнэлэх гэсэн 2 хэлбэрээс нэгийг сонгон ИМҮ-г хийх чиглэлийг тодорхойлно.

4.4. Хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг үнэлэх бол ИМҮ хийх ажилтан ЭМТҮЧАБ-ын алба/багаас тогтоосон хугацаа, өгөгдсөн тусламж, үйлчилгээний чиглэлийн дагуу хийгдсэн үйл ажиллагааны баримжуулалтаас сонгон авна.

4.5. Үнэлгээ хийгч нь батлагдсан хяналтын хуудсын дагуу үнэлгээ хийж тасаг/нэгжийн эрхлэгчид өгнө.

4.6. Тасаг/нэгжийн эрхлэгч үр дүнг нь нэгтгэн ЭМТҮЧАБ-ын алба/багт танилцуулна.

4.7. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь тасаг/нэгжүүдийг ИМУ-ний мэдээллийн сангаар хангах, үнэлгээний нэгдсэн мэдээллийн сантай байж шаардлагатай сэдэв, хариу шаардсан асуудлуудыг хэлэлцэх үүрэг хүлээнэ.

4.8. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь байгууллагын тасаг /нэгжээс илгээсэн ИМУ - ний үр дүнг шалгаж, дүгнэлт гарган, байгууллагын удирдлага, хамт олонд танилцуулан, цаашид авах арга хэмжээг төлөвлөн ажиллана.

4.9. Эмнэлгийн бус мэргэжилтнүүдийн ИМУ-ийг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж зохион байгуулж ЭМТҮЧАБ-ын алба/баг-т танилцуулна.

4.10. ЭМТҮЧАБ-ын алба/баг нь “хангалтгүй” үнэлэгдсэн үйл ажиллагааг тухайн тасаг/нэгжийн түвшинд хэлэлцэн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагааг төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хянана.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны .12. сарын .12. -ны
өдрийн .1006. дугаар тушаалын
тавдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ЧАНАРЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгжийн чиг үүрэг

1.1. Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын технологи, чанарын удирдлагыг хариуцан, ЭМТҮЧАБ-ын үйл ажиллагааг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх, тушаалын төслийн саналыг боловсруулж, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагад танилцуулна.

1.3. Эрүүл мэндийн газар, байгууллагуудын ЭМТҮЧАБ-ын албадын үйл ажиллагаанд дэмжин туслах, зөвлөх, хяналт тавьж, үнэлэлт, дүгнэлт өгч зөвлөмж гаргаж, биелэлтийг хангуулна.

1.4. Эмнэлзүйн удирдамж заавар, стандарт, чанарын баталгаажилтын үйл ажиллагааны хэрэгжилтэнд үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр сургалт зохион байгуулна.

1.5. Эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөж байгаа тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилтэд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, дүгнэнэ.

1.6. ЭМТҮЧАБ-ын заавар, гарын авлагуудыг шинэчлэн боловсруулна.

1.7. Чанарын талаархи сайн туршлагыг нэвтрүүлэх, туршлага судлах зөвлөх үйлчилгээ авах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

1.8. ЭМТҮЧАБ-ын чиглэлээр хүний нөөцийг чадавхижуулах сургалт зохион байгуулна.

1.9. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийж холбогдох байгууллагуудтай хамтран хариу арга хэмжээ авна.

1.10. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанарын нэгдсэн сүлжээний цахим мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, тайлагнах, эргэн мэдээлэх, харилцан суралцах орчин бүрдүүлнэ.

1.11. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

**Хоёр. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй
байдлын талаарх үндсэн чиг үүрэг**

2.1. Нийслэлийн Эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиг үүрэг хариуцсан хэлтэс ажиллах ба Хэлтсийн дарга, Чанарын баталгаажилт хариуцсан мэргэжилтэн, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэл хариуцсан мэргэжилтэнтэй байна.

2.2. Аймагын эрүүл мэндийн газарт ЭМТҮЧАБ-ын албаны үүргийг Эмнэлгийн тусламжийн хэлтэс хэрэгжүүлэх ба эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, эрсдэл хариуцсан мэргэжилтэн, Чанарын баталгаажилт хариуцсан мэргэжилтэнтэй байна. Эрүүл мэндийн байгууллагын ЭМТҮЧАБ-ын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

2.3. Харъяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагыг тогтолцоог бэхжүүлэн, ЭМТҮЧАБ-ын талаар гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, дэмжлэгт хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллана

2.4. Магадлан итгэмжлэлд бэлтгэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, магадлан итгэмжлэлийн явцын хяналт үнэлгээг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн хөндлөнгийн үнэлгээний баг байгуулж гэрээний дагуу дээрх үүргийг хамтран хэрэгжүүлнэ.

2.5. Эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ, оношилгоо технологийн мөрдөлт, стандарт, удирдамж, заавар журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ дүгнэлт өгч, эргэн мэдээлнэ.

2.6. Эрүүл мэндийн байгууллагын үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол, эрсдэлд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудтай хамтран хариу арга хэмжээ авна.

2.7. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн агуулга, цар хүрээг тодорхойлох, үнэлгээ хийх, асуудал дэвшүүлэх зэрэг үйл ажиллагааг мэргэжлийн нийгэмлэг холбоод, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хийнэ.

2.8. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанарын нэгдсэн сүлжээний цахим мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, тайлагнах, эргэн мэдээлэх, харилцан суралцах орчин бүрдүүлнэ.

2.9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгч ба эмнэлгийн ажилтны сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлаар чанарын судалгааг хийнэ.

2.10. Тусламж, үйлчилгээний инновацийг нэвтрүүлэх, үүдгэл санаачлагыг дэмжин, туршлагыг түгээн дэлгэрүүлнэ

2019 оны 12 сарын 12 -ны
 өдрийн А/566 дугаар тушаалын
 зургаадугаар хэвсрэлт

**НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
 АЛБА/БАГИЙН ДАРГЫН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

Албан тушаалын нэр:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/багийн дарга	Аюулгүй байдлын
Албан тушаалын зорилго:	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах	Тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах
Албан тушаалын зорилт:	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах 2. Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх 3. Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах 4. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах 	Тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах
Тавигдах шаардлага:	<ol style="list-style-type: none"> 1) Холбогдох хууль журам болон тухайн байгууллагын ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлыг хангасан 2) Эрүүл мэндийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан 3) Эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой 4) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай 5) Багаар ажиллах чадвартай 6) Ёс зүйн тохиолдол зөрчил гаргаж байгаагүй 	Ажлын ажилтныг хангасан ажилласан аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр санал танилцуулан шийдвэрлүүлэх

Чиг үүрэг:

- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд:
1. Байгууллагын зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх
 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврын мөрдөлтийн хэрэгжилтийг хангуулж, удирдан зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
 3. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах
 4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, мэдний хүсэлтийг шийдвэр гаргалтанд тусгасан талаар эргэн мэдээлэх
 5. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан удирдах зөвлөл, удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх
 6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлаар төр ба ББ, мэргэжлийн нийгэмлэг, иргэнтэй хамтран ажиллах.

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 12 -ны
өдрийн А/366 дугаар тушаалын
зургаадугаар хавсралт

**НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
АЛБА/БАГИЙН ДАРГЫН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

Албан тушаалын нэр:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/багийн дарга
Албан тушаалын зорилго:	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах
Албан тушаалын зорилт:	<ol style="list-style-type: none"> 1. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах 2. Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх 3. Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах 4. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, тайлагнах
Тавигдах шаардлага:	<ol style="list-style-type: none"> 1) Холбогдох хууль, журам болон тухайн байгууллагын ажилтны ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг хангасан 2) Эрүүл мэндийн байгууллагад 8-аас доошгүй жил ажилласан 3) Эрдмийн буюу мэргэжлийн зэрэг цолтой 4) Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай 5) Багаар ажиллах чадвартай 6) Ёс зүйн тохиолдол зөрчил гаргаж байгаагүй
Чиг үүрэг:	<p><u>Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах зорилтын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, үнэлэлт дүгнэлт өгөх 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврын мөрдөлтийн хэрэгжилтийг хангуулж, удирдан зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх 3. Хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, магадлан итгэмжлэл, мэргэжлийн хяналтын шалгалтын дүн, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах 4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлүүлэх ажлыг хамтран ажиллах, тэдний хүсэлтийг шийдвэр гаргалтанд тусгасан талаар эргэн мэдээлэх 5. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан удирдах зөвлөл, удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх 6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудлаар төр ба ТББ, мэргэжлийн нийгэмлэг, иргэнтэй хамтран ажиллах.

Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

1. Байгууллагын тасаг/нэгжүүдийн чанар, аюулгүй байдлын багийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ өгөх, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад дэмжлэг тусалцаа үзүүлэх
2. Эмнэлэгт шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд мэргэжлийн зайлшгүй шаардлагатай чиг баримжааг таниулах ажлыг зохион байгуулах
3. Байгууллагын чанар, аюулгүй байдлын багийг зохион байгуулан гийцүүдийг томилж байгууллагын ажилтануудын албан тушаалын тодорхойлолтод чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр тусган чиг үүргийн дагуу ажиллуулах
4. Бүх шатны менежерүүд бусад ажилтны ажлыг гүйцэтгэлийн үнэлгээнд чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлэх шалгуурыг хянах, батлуулах
5. Чанар, аюулгүй байдлын чиглэлээр үр дүнтэй ажилласан ажилтан, алба, баг, хороог урамшуулал олгох, шагнах, дэмжлэг үзүүлэх тухай саналыг оруулах
6. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр чанар аюулгүй байдлын чиглэлээр хангалтгүй үнэлүүлсэн ажилтан, алба, баг, хороог холбогдох журмын дагуу харилцлага тооцох саналыг байгууллагын удирдах зөвлөлд танилцуулах
7. Баримт бичгийн кодын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах хэвшүүлнэ.

Албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд:

1. ЭМТҮЧАБ-ын алба/багийг чанарын удирдлагаар хангаж, чанарын бүх үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, үр дүнг тооцох
2. Тархвар судлал, хүний нөөц, лаборатори, сувилахуй, эм зүй, нян судлал, санхүү, аж ахуй, эмчилгээний хороо, зөвлөл болон тасаг/нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, чанар сайжруулах үйл ажиллагаанд хамт олны оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллах
3. Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд болон эрүүл мэндийн мэргэжилтэнүүдэд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн чиглэлээр сургаж чадавхижуулах ажлыг тогтмол зохион байгуулахад чанар, аюулгүй байдлын албаны оролцоог хангах
4. Байгууллагын удирдлага, эмч, ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр хийх ажлын тусгаж, ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд чанар аюулгүй байдлын чиглэлээр хийсэн ажлыг үнэлэх.
5. Тусламж, үйлчилгээний чанар, эрсдэл аюулгүй байдлыг сайжруулах арга хэрэгслүүдийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, мэдээлэх, сайн туршлагыг дэлгэрүүлэх, чанарын өдөрлөг, туршлага судлах, судлуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж, үр дүнг тооцох

Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлтэй холбоотой хууль тогтоомж бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийх, төлөвлөх зорилтын хүрээнд:

1. Байгууллагад тохиолдож болох аюул ослыг тодорхойлж тооцоолох, аюул осолд хүргэж болох хүчин зүйлсийг илрүүлэх, эрсдэлийг бууруулах, арилгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.
2. Эрсдэл нүүрлэсэн тохиолдолд түүнийг хохирол багатайгаар даван туулах, ирээдүйд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлээс ангид байх ажлуудыг зохион байгуулна.
3. Эмнэл зүйн эрсдэлийн түүх, мэдээний сан ажиллуулах, тохиолдлын үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах ажлыг зохион байгуулах
4. Халдварын хяналт, сэргийлэлтийн үндсэн шаардлагуудын мөрдөлтөнд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр удирдах
5. Халдварын дэгдэлтийн байдалд судалгаа хийх, дүгнэлт гаргах, хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах
6. Эмнэлгийн тулгамдсан асуудал болон эрсдэл өндөр тасаг/нэгжийг тогтоох,

шийдвэрлүүлэх

7. Үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтны аюулгүй байдал, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн тогтолцоо, зохион байгуулалтын талаар санал гаргах, шийдвэрлүүлэх, үр дүнг тооцох
8. Эмнэлгийн гадаад, дотоод орчин болон эмнэлзүйн аюулгүй байдалд холбогдох алба, мэргэжилтэнтэй хамтран үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах
9. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдлыг бүртгэх, мэдээлэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх /цаасаа болон цахим/ тогтолцоог цогцоор нь хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах
10. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад дотоод орчны эрсдэлт нөхцөл байдал, эмнэлзүйн эрсдэлийг илрүүлэн бүртгэх тогтолцоог бий болгон эрсдэлийг эрэмбэлэх, үнэлэх хариу арга хэмжээ авах ажилд дэмжлэг үзүүлэх
11. Үйлчлүүлэгчийн санал гомдол, сэтгэл ханамжийн судалгааг зохион журмын дагуу авах, судалгааны үр дүнг шийдвэр гаргалт, төлөвлөлтөд ашиглах, арга хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг эргэн мэдээлэх ажлыг зохион байгуулна.
12. Чанар аюулгүй байдлын мэдээний санг тогтмол ажиллуулан журамд заасны дагуу дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх ажилд хяналт тавих
13. Үйлчлүүлэгчийг хүлээн авах, тусламж, үйлчилгээ үзүүлэх, хянах, хүлээлцэх, эмнэлгээс гаргах, хүлээлгэн өгөх үйл ажиллагааны зохион байгуулалтанд хяналт тавих
14. Үйлчлүүлэгчид хүргэж байгаа лавлагаа мэдээллийн үйлчилгээнд хяналт тавих, зорилтот бүлгийн үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээ, шаардлагыг хангасан орчин бүрдүүлэх

**ХОЁР: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН АЛБА/БАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛ ХАРИУЦСАН
МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

Албан тушаалын нэр:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер	байдлын алба
Албан тушаалын зорилго:	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны явцад дотоод болон гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс үүсч болох эрсдэлийн хүчин зүйлс, шалтгаан, үр дагаврыг тогтоох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах	
Албан тушаалын зорилт:	1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах 2. Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, 3. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах дэвшилтэт санаа санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх	
Тавигдах шаардлага:	- Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн - Мэргэжлээрээ 3-с доошгүй жил ажилласан байх - Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын чиглэлээр 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай - Багаар ажиллах чадвартай - Ёс зүйн тохиолдол зөрчил гаргаж байгаагүй	

Чиг үүрэг:

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал хангах зорилтын хүрээнд.

1. Тусламж, үйлчилгээний бүх чиглэлд үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах үйлчилгээ үзүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
2. Үйлчлүүлэгчидтэй харилцаа тогтоох, мэдээлэл өгөх бүх үйл ажиллагааг баталгаажуулах, үйл явцыг тодорхойлсон журам, заавар боловсруулан журмын хэрэгжилтэнд хяналт тавих
3. Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангасан тогтолцоог бүрдүүлж хяналт тавих
4. Шинжилгээ, эмчилгээ, оношлогоо, мэс ажилбарын аюулгүй байдлыг хангах, хянах, заавар мөрдүүлэн ажиллан хяналт үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч үр дүнг тооцох
5. Нянгийн тэсвэржилтийг бууруулах, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, цацрагийн аюулгүй байдал, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын аюулгүй байдал, үйлчлүүлэгч, сорьц тээвэрлэхтэй холбоотой аюулгүй байдал алдагдах гэх мэт үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааг хянан, заавар мөрдүүлэн ажиллан хяналт үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч үр дүнг тооцож ажиллах
6. Шинжилгээний аюултай хариуг бүртгэх, мэдээлэх, баталгаажуулах үйл явцыг тодорхойлох журам боловсруулж мөрдүүлэх
7. Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унахаас сэргийлэх журам боловсруулж, шаардлагатай санал, шийдвэрлэх арга замыг удирдлагад танилцуулах
8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, тархвар судлал, хүний нөөц, лаборатори, сувилахуй, эм зүй, нян судлал, санхүү, аж ахуй, эмчилгээний асуудал хариуцсан тасаг/нэгжийн уялдаа холбоог хангах
9. Чанар, аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлэх, ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур боловсруулан үнэлж үр чадварын урамшуулал, хариуцлага тооцох саналыг нэгтгэж чанар аюулгүй байдлын албаны засирал /дарга/-д тайлагнах
10. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой тохиолдол мэдэгдэх тогтолцоог

хэрэгжүүлэн санд бүртгэгдсэн тохиолдлын үндсэн шалтгааны дүн шинжилгээ хийх, шалтгааныг тогтоох урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, журамд заасны дагуу арга хэмжээ авч тогтоосон хугацаанд чанарын нэгдсэн санд мэдээлэх

Эрсдэлийг мэдээлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах зорилтын хүрээнд:

1. Эрсдэл аюулгүй байдал хариуцсан менежер нь байгууллагын эрсдэлийн багийн гишүүдтэй хамтран үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтны аюулгүй байдалтай холбоотой гадаад дотоод орчны эрсдэл, эмнэлзүйн эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах
2. Байгууллагын өдөр тутмын үйл явц, дотоод болон гадаад орчны талаар эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг хянах, бууруулах зорилгоор байгууллагын эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг боловсруулан, эрсдэлийг бууруулах хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийн үнэлгээг хийх ажлыг удирдлагаар хангах
3. Байгууллагын удирдлагын багт эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар тайлагнах
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой аюул, эрсдэлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээг баримтжуулан дүн шинжилгээ хийж түгээн дэлгэрүүлэх
5. Өөрийн байгууллагын эрсдэл, аюулгүй байдалтай холбоотой санг ажиллуулах.
Үүнд:
 - Тохиолдлын мэдээ, аюулгүй байдлын тойрон үзлэг, хөндлөнгийн хяналт шалгалт үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, иргэд, байгууллагаас ирсэн санал, гомдол, хүсэлт болон бусад эх үүсвэрээс гадаад, дотоод орчны болон эмнэл зүйн бүртгэгдсэн эрсдэлийн мэдээллийг хянах.
 - Эрсдэл гэж бүртгэсэн тохиолдол бүрийг журамд заасны дагуу эрэмбэлж үнэлэх
 - Үнэлж эрэмбэлсэн эрсдэлийн нэгтгэн дүн шинжилгээ хийж, холбогдох журамд заасны дагуу дараах шатлалын байгууллагад тайлагнах.
6. Гадаад болон дотоод орчны эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг эрсдэлийн багтай хамтран урьдчилан төлөвлөж шийдвэрлэх
7. Эрсдэлийг бүртгэх, үнэлэх, эрэмбэлэх хариу арга хэмжээ авах талаар байгууллагын ажилтануудад сургалт зохион байгуулах

Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах дэвшилтэт санаа санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

1. Эмнэл зүйн эрсдэл гарахаас сэргийлэх суралцах орчин бүрдүүлэн, давтан гаргахгүй байх талаар холбогдох тасаг/нэгж, алба, баг, хороо, ажилтантай хамтрах
2. Тусламж, үйлчилгээний тохиолдолд дүн шинжилгээ хийх, дахин давтагдахаас сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, алдаанаас харилцан суралцах орчин бүрдүүлж эрүүл мэндийн ажилтанд дэмжлэг үзүүлэх
3. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, мэдээлэх
4. Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн ээлтэй орчны аюулгүй байдлыг хангах талаар олон улсад хэрэгжүүлж буй сайн туршлага, дэвшилтэт арга хэрэгсэлийг нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах
5. Чанарын өдөрлөг зохион байгуулах, ижил мэргэжилтний үнэлгээг хийх гэх мэт чанар сайжруулах арга хэрэгсэлийг нэвтрүүлж үр дүнг тооцох
6. Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтануудад тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн чиглэлээр сургаж чадавхижуулах ажлыг тогтмол зохион байгуулахад оролцох
7. Чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаарх сургалтыг эрүүл мэндийн ажилтануудын дунд тусгай хөтөлбөрийн дагуу тогтмол зохион байгуулах

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЛБА/БАГИЙН ЧАНАРЫН МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын нэр:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба /баг/-ийн чанарын менежер	
Албан тушаалын зорилго:	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах	
Албан тушаалын зорилт:	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй хангахад чанарын хяналт тавьж ажиллах 2. Чанар сайжруулах арга хэрэгслийг нэвтрүүлэх, чанарын баталгаажуулалтыг хангаж ажиллах 3. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах дэвшилтэт санаа санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх 	
Тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> - Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн - Мэргэжлээрээ 5-с доошгүй жил ажилласан байх - Эмнэлзүйн мэргэшсэн эмч - Эрүүл мэндийн чанарын удирдлагын чиглэлээр сургалтанд хамрагдсан 	

Чиг үүрэг:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг жигд хүртээмжтэй хангахад чанарын хяналт тавьж ажиллах зорилтын хүрээнд:

1. Байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулан биелэлтэнд хяналт тавих
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, заавар, аргачлал, тушаал, шийдвэрийн мөрдөлтөд хяналт хийж, дэмжлэгт удирдлагаар хангах.
3. Байгууллагын тасаг/нэгжийн чанарын багуудын сар, улирлын ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих
4. Хөндлөнгийн хяналт үнэлгээний байгууллагын зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг ханган, гүйцэтгэлд хяналт тавин хяналтын мөрөөр хийсэн ажлын нэгтгэж чанар аюулгүй байдлын албаны захирал /дарга/-д тайлагнах
5. Эмчилгээ үйлчилгээтэй холбоотой баримт бичиг / өвчтөний түүх болон бусад/ хөтлөх, зохицуулалтыг зохих журмын дагуу хяналт тавих
6. Албаны дотоод үйл ажиллагааны хэрэгжилтийг тасралтгүй ханган тусламж, үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, засан сайжруулах арга хэмжээ авах

Чанар сайжруулах арга хэрэгсэлийг нэвтрүүлэх, чанарын баталгаажуулалтыг хангаж ажиллах зорилтын хүрээнд:

1. Оношлогоо, эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, чанар, хүртээмжийг хангах / үйлчлүүлэгчийн ачаалал, үйлээгдэл, эрэлт хэрэгцээ, урсгал хөдөлгөөн/ тогтолцоог бүрдүүлж ажиллах
2. Чанар, аюулгүй байдлын үйл ажиллагааг үнэлэх, ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур боловсруулан үнэлж, ур чадварын урамшуулал, хариуцлага тооцох саналыг нэгтгэж чанар, аюулгүй байдлын албаны даргад тайлагнах
3. Байгууллагын тасаг/нэгжийн чанарын багуудтай хамтран хяналтын хуудас боловсруулан нэвтрүүлэх, ижил мэргэжилтэний үнэлгээ хийх, чанарын өдөрлөг, сургалт зохион байгуулах зэрэг чанарыг тасралтгүй сайжруулах арга хэрэгсэлийг

хэвшүүлэх

4. Чанар, аюулгүй байдлыг сайжруулах бүхий л үйл ажиллагаанд эрүүл мэндийн ажилтануудыг оролцоог жигд ханган, үйлчлүүлэгчээс ирсэн гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах
5. Тусламж, үйлчилгээний тохиолдолд дүн шинжилгээ хийх багт орж ажиллан, дахин давтагдахаас сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг удирдан чиглүүлэх
6. ОУ-ын стандарт нэвтрүүлэх, дотоод болон гадаадын чанарын баталгаажилт хийх эрх бүхий байгууллагуудын магадлан итгэмжлэл авах, магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээг холбогдох алба, баг, хороотой хамтран хийх, магадлан итгэмжлийн зөвлөмжийн биелэлтийн хангуулах, баримт бичгийг бүрдүүлэхэд чанарын багийг удирдан, чиглүүлэх, арга зүйгээр хангах

Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах дэвшилтэт санаа санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

1. Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах, чанарын баталгаажилтыг хангахад чиглэсэн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, харилцан суралцах орчин бүрдүүлж ажиллах
2. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах талаар олон улсад хэрэгжүүлж буй сайн туршлага, дэвшилтэт арга хэрэгслийг нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг зохион байгуулах
3. Чанарын өдөрлөг зохион байгуулах, ижил мэргэжилтний үнэлгээг хийх гэх мэт чанар сайжруулах арга хэрэгсэлийг нэвтрүүлж үр дүнг тооцох
4. Чанарын багуудын үйл ажиллагааг дүгнэж сайн туршлага солилцох, шинэ мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах
5. Шинээр ажилд орсон эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтануудад тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн чиглэлээр сургаж чадавхижуулах ажлыг тогтмол зохион байгуулахад оролцох
6. Чанар, аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын талаарх сургалтыг тогтмолжуулах

**ДӨРӨВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ
БАЙДЛЫН АЛБА/БАГИЙН ЧАНАРЫН МЭДЭЭЛЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЕНЕЖЕРИЙН АЖЛЫН ЧИГ ҮҮРЭГ**

Албан тушаалын нэр:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба/баг/-ийн тусламж, үйлчилгээний чанарын мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн мэдээллийг баримтжуулах, нэгтгэх, нотолгоо бүхий мэдээллээр хангах
Албан тушаалын зорилго:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн мэдээллийг бүртгэх, баримтжуулах	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын нотолгоо бүхий мэдээллээр хангах
Албан тушаалын зорилт:	<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, нэгтгэх 2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, нэгтгэх 3. Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, нэгтгэх 	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн мэдээллийг баримтжуулах, нэгтгэх, нотолгоо бүхий мэдээллээр хангах
Тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн эрүүл мэнд, анагаах ухааны боловсрол олгох сургуулийг төгссөн - Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн - Мэргэжлээрээ 2-с досшгүй жил ажилласан, чанар, аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд хамрагдсан байх - Компьютерийн өргөн хэрэглээний программыг ашиглаж чаддаг байх 	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн мэдээллийг баримтжуулах, нэгтгэх, нотолгоо бүхий мэдээллээр хангах
Чиг үүрэг:		
<u>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн мэдээллийг бүртгэх, баримтжуулах зорилтын хүрээнд:</u>		
<ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн ажилтануудаас илгээсэн тохиолдлын болон эрсдэлийн мэдээллийг хүлээн авч нэгдсэн дугаар олгож мэдээний цахим санд бүртгэнэ. 2. Эрүүл мэндийн байгууллагуудын эрсдэл, аюулгүй байдалтай холбоотой тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлнэ. 3. Чанар, аюулгүй байдлын албаны хурлын тэмдэглэл, ирсэн явсаг бичиг хүлээн авах, хүргэх үйл ажиллагааг хариуцна. 4. Үйлчлүүлэгчээс ирсэн санал гомдлыг хүлээн авах, нэгтгэн чанар, аюулгүй байдлын албаны дэд захирал, дарга / менежер/-т танилцуулна. 5. Чанар, аюулгүй байдлын албанаас тасаг/нэгж, чанарын багуудад өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлсэн тайланг хүлээн авч нэгтгэнэ. 		
<u>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын нотолгоо бүхий мэдээллээр хангах зорилтын хүрээнд:</u>		
<ol style="list-style-type: none"> 1. Тасаг/нэгжүүдэд хийгдсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн, гарсан саналуудыг нэгтгэн чанар аюулгүй байдлын албаны хурлаар хэлэлцүүлнэ. 2. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой бүртгэсэн тохиолдлыг, эрсдэлийн тоог нэгтгэн сар бүр танилцуулна. 3. Чанар, аюулгүй байдлын албаны хурлыг зохион байгуулан дотоод бичиг хэргийг хариуцан ажиллана. 4. Чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын талаар зохион байгуулагдах сургалтын зарыг тасаг/нэгжүүдэд түгээх, сургалтын бүртгэл, баримтжуулалтын ажлыг зохион байгуулна. 5. Чанар аюулгүй байдалтай холбоотой баримт бичгийг архивлах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэнэ. 		
<u>Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар үйлчлүүлэгчийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, нэгтгэх зорилтын хүрээнд:</u>		
<ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчидтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг тооцон ажиллах зэргээр тусламж, үйлчилгээний чанарыг 		

сайжруулах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2. Үйлчлүүлэгчийг тусламж, үйлчилгээнд чиглүүлэх, лавлагаа мэдээллийн үйлчилгээг зохицуулан мэдээлэх үйлчилгээний цэгүүдэд хяналт тавина.
3. Үйлчлүүлэгчээс ирсэн санал гомдлыг хүлээн авч нэгтгэн чанар, аюулгүй байдлын албанд танилцуулна.
4. Үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй орчин бүрдүүлж ажиллана/ санал, гомдлын дэвтэр, нээлттэй утас, хайрцаг/.
5. Байгууллагын цахим хуудсанд болон самбарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар мэдээлэл тавьж эрүүл мэндийн ажилтан болон иргэдийг мэдээллээр хангана.